



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Батбаярын ЖАРГАЛАН**

ТАНАА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-23, Факс: 32-70-16
E-mail: jargalan@parliament.mn
http://www.parliament.mn

2025.06.23 № УИХ-03/7689
танай _____-ны № _____-т


Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасан хууль санаачлах эрхийн хүрээнд Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.ЖАРГАЛАН

Ж.АЛДАРЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ

Н.АЛТАНШАГАЙ

00000030

Д.АМАРБАЯСГАЛАН

С.АМАРСАЙХАН

О.АМГАЛАНБААТАР

Ч.АНАР

А.АРИУНЗАЯА

Т.АУБАКИР

Х.БААСАНЖАРГАЛ

Ц.БААТАРХҮҮ

М.БАДАМСҮРЭН

Э.БАТ-АМГАЛАН

Б.БАТБААТАР


Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

00000030



О.БАТНАЙРАМДАЛ

Н.БАТСҮМБЭРЭЛ

Ж.БАТСУУРЬ

Х.БАТТУЛГА


Б.БАТЦЭЦЭГ

П.БАТЧИМЭГ

Э.БАТШУГАР

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАТ-ЭРДЭНЭ



Б.БАЯРБААТАР

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЕН

Э.БОЛОРМАА

Х.БОЛОРМАА

00000030

Х.БУЛГАНТУЯА



Д.БУМ-ОЧИР



Ш.БЯМБАСҮРЭН

С.БЯМБАЦОГТ

Ж.ГАЛБАДРАХ

Г.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Ж.ГАНБААТАР

А.ГАНБААТАР



Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ

Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

М.ГАНХҮЛЭГ

Х.ГАНХУЯГ



00000030

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Х.ЖАНГАБЫЛ



Д.ЖАРГАЛСАЙХАН

С.ЗАМИРА


Б.ЗАЯАБАЛ



Ж.ЗОЛЖАРГАЛ

С.ЗУЛПХАР

Ц.ИДЭРБАТ



Л.ЛОДОЙСАМБУУ



Г.ЛУВСАНЖАМЦ



С.ЛҮНДЭГ

00000030

М.МАНДХАЙ

Л.МӨНХБААТАР



Ц.МӨНХБАТ

Л.МӨНХБАЯСГАЛАН

Т.МӨНХСАЙХАН



Б.МӨНХСОЁЛ

П.МӨНХТУЛГА

Ц.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН


Б.НАЙДАЛАА

Н.НАРАНБААТАР

П.НАРАНБАЯР

М.НАРАНТУЯА-НАРА

Ч.НОМИН



О.НОМИНЧИМЭГ

00000030


Н.НОМТОЙБАЯР



Э.ОДБАЯР


С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР



Г.ОЧИРБАТ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



Б.ПУНСАЛМАА

Д.ПҮРЭВДАВАА

Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

П.САЙНЗОРИГ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН



М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД

00000030



Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТҮВШИН

Б.ТУЛГА



Х.ТЭМҮҮЖИН

Г.ТЭМҮҮЛЭН


А.УНДРАА

Ч.УНДРАМ

Д.ҮҮРИЙНТУЯА

Н.УЧРАЛ

Б.УЯНГА



Г.УЯНГАХИШИГ

Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН

Дав.ЦОГТБААТАР

00000030

Дам.ЦОГТБААТАР



О.ЦОГТГЭРЭЛ



С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН



Ө.ШИЖИР




Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН

Д.ЭНХТҮВШИН



Д.ЭНХТУЯА

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН

00000030



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Батбаярын ЖАРГАЛАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-23, Факс: 32-70-16
E-mail: jargalan@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.06.19 № УИХ-03/4558
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар дугаар зүйл, Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг хавсаргав.

Хавсралт 34 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.ЖАРГАЛАН

00000026

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.10.Тулгар төр байгуулагдсаны ой, Их Монгол Улс байгуулагдсаны ой, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Үндэсний эрх чөлөөний хувьсгал, Ардын хувьсгал, Ардчилсан хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Б.ЖАРГАЛАН

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Үндэсний их баяр наадам нь "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт баяр" билээ¹. Монголчуудын үндэсний бахархлыг бадрааж, нүүдлийн соёл иргэншлийг дэлхий дахинаа сурталчилдаг Үндэсний их баяр наадам бол монгол түмний үндэсний ижилсэл-ондоошлын ухамсарт гүн нөлөөтэй чухал үнэт зүйл, арга хэмжээ юм. Тиймээс Монгол Улсын түүхийн бүхий л цаг хугацаанд монголчуудын үндэсний ухамсрыг сэргээх үйл хэрэгт онцгой үүрэг гүйцэтгэсэн байдаг. Үндэсний их баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдсон харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний их баяр наадмын тухай хуулиар тусгайлан зохицуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван хоёрдугаар зүйлийн 4-т, "Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл мөн" гэж заасан бөгөөд Үндэсний их баяр наадмын нээлтээр Төрийн тугийг улсын баяр наадмын талбайд хүндэтгэн залж баяр наадмыг эхлүүлдэг. Тиймээс наадам бол Монгол Улсын төрийн хүндэтгэлийн ёслол юм. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 1-т, "Монгол Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн" гэж заасанчлан Үндэсний их баяр наадмыг Монгол Улсын Ерөнхийлөгч нээж үг хэлдэг. Баяр наадмын нээлт, хаалтын үйл ажиллагааг Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу зохицуулж, Монголын ард түмний төрт ёс, түүхэн уламжлалыг хадгалж ирсэн.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.10-т, "Их Монгол Улс байгуулагдсаны ой болон үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Ардын хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ" гэж заасан нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүхэнд ач холбогдол бүхий тэмдэглэлт ойн баярыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх нь зүйтэй гэсэн санааг агуулжээ. Хэдий уг хуульд зөвхөн хоёр түүхэн ойн баярыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх тухай заасан боловч үе үеийн Ерөнхийлөгч нарын нээлт, хаалтын үг болон баяр наадмын тухай албаны мэдээлэлд Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, Ардчилсан хувьсгалын ойн баярын ойн талаар олонтоо дурдаж, цохон тэмдэглэсэн байдаг. Тиймээс

¹ Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт

Монгол Улсын түүхэнд чухал ач холбогдол бүхий Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, Ардчилсан хувьсгалын ойн баяр наадмыг Их Монгол Улс байгуулагдсаны ой, Ардын хувьсгалын ой, улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх талаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд тусгах шаардлагатай гэж үзэж байна.

1.2. Практик шаардлага

Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн асар өргөн агуулгатай билээ. Монгол Улсын тусгаар тогтнол, төрт ёсны түүх зөвхөн Монгол Улс байгуулагдсаны ой болон Ардын хувьсгалын ойгоор хязгаарлагдахгүй бөгөөд монголчуудын үндэсний ухамсарт гүнзгий нөлөөлөл үзүүлсэн тодорхой түүхэн үйл явдлуудыг Үндэсний их баяр наадмын хүрээнд тэмдэглэх нь зүйтэй юм.

Тулгар төр байгуулагдсан ой, Их Монгол Улс байгуулагдсан ой, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Үндэсний эрх чөлөөний хувьсгал, Ардын хувьсгал, Ардчилсан хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх асуудлыг хуульчилснаар Үндэсний их баяр наадам Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүхэн уламжлалыг бүрэн илэрхийлэх боломж бүрдэнэ.

Хуульд тусгайлан заагаагүй боловч дээрх түүхэн ач холбогдол бүхий ойн баяруудыг улсын баяр наадмыг тэмдэглэх үеийн албаны мэдээлэлд дурдаж ирсэн практик бий. Тухайлбал, 2019 онд Үндэсний их баяр наадмыг тэмдэглэхэд албан ёсны эх сурвалжид Тулгар төрийн 2228, Их Монгол Улс байгуулагдсаны 813, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 108, Ардын хувьсгалын 98, Ардчилсан хувьсгалын 30 жилийн ойн баярын талаар цохон тэмдэглэж байжээ. Харин 2024 онд Тулгар төр байгуулагдсаны түүхт 2233, Их Монгол Улс байгуулагдсаны 818, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 103 жилийн ойн баярын талаар онцолж байв.

2003 ба 2022 онд батлагдсан Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зохих заалтыг харьцуулбал:

Үндэсний их баяр наадмын тухай хууль /2003/	Үндэсний их баяр наадмын тухай хууль /2022/
2.5.Их Монгол Улс байгуулагдсаны тэгш ой, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Ардын хувьсгалын ой болон нийслэлийн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ.	5.10.Их Монгол Улс байгуулагдсаны ой болон үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Ардын хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ.

2003 оны хуучин хууль болон одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 2022 оны хуульд Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ойг тэмдэглэх талаар тусгайлан заагаагүй боловч үе үеийн Монгол Улсын Ерөнхийлөгч нар Үндэсний их баяр наадмыг нээж үг хэлэхдээ Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны ойн талаар дурдаж байсан байна. Ардчилсан хувьсгалын талаар мөн хуульд заагаагүй ч, 2019 онд Монгол Улсын Ерөнхийлөгч дурдаж байсан бол 2024 онд дурдахгүй өнгөрч байжээ. Монгол Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд Үндэсний их баяр наадмыг нээж үг хэлэхдээ Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүхийн онцлох үйл явдлын ойн баярыг хамтатган тэмдэглэх талаар бүрэн хэлж байх нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцнэ.

Тиймээс Монгол Улсын төрт ёсны түүхэнд чухал ач холбогдол бүхий дээрх ойн баяруудыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх талаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд тусгаснаар Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүхэн уламжлалыг бүрэн илэрхийлж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг төлөвшүүлэх боломж бүрдэнэ.

Хоёр. Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Их Монгол Улс байгуулагдсаны ой болон үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Ардын хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэхээс гадна Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, Ардчилсан хувьсгалын ойн баяр наадмыг мөн хамтатган тэмдэглэх тухай заалтыг тусгасан бөгөөд энэхүү өөрчлөлт нь Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5.10 дахь хэсгийг хамарна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, тэдгээрийн шийдвэрлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Үндэсний их баяр наадам зөвхөн Их Монгол Улс байгуулагдсаны ой болон Ардын хувьсгалын ойн баяр наадмаар хязгаарлагдахгүйгээр мөн албан ёсоор Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, Ардчилсан хувьсгалын ойн баяр наадмыг хамрах эрх зүйн үндэс бүрдэнэ. Энэ нь монголчуудын үндэсний нэгдмэл үнэт зүйлсийг бэхжүүлэх, эв нэгдлийг хангах олон талын ач холбогдолтой.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хуулийн төслийг дагаж бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт *"Монголын ард түмэн [...] улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, [...] төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, [...] эх орондоо иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгон"* Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхагласан байдаг. Тиймээс Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэддэг баяр болох Үндэсний их баяр наадмыг Тулгар төрийн ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, Ардчилсан хувьсгалын ойн баяр наадамтай хамтатган тэмдэглэх талаар хуульд заах нь Үндсэн хуульд бүрнээ нийцнэ.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь хоёр зүйлтэй. Нэгдүгээр зүйлд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.10 дахь хэсэгт *“Их Монгол Улс байгуулагдсаны ой болон үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Ардын хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ”* гэснийг *“Тулгар төр байгуулагдсаны ой, Их Монгол Улс байгуулагдсаны ой болон үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ойн, Ардын хувьсгалын ойн, Ардчилсан хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ”* гэж өөрчлөн найруулахаар тусгасан.

Монголын тулгар төр гэж Монголын нутаг дэвсгэр дээр байгуулагдсан анхны төрт улсыг хэлэх бөгөөд үүнийг Хүннүгийн эзэнт гүрэн (МЭӨ III зуун – МЭ 93 он)-тэй холбон ойлгодог. Хүннү улс нь Монголын газар нутаг дээр үүссэн анхны төрт улс бөгөөд төвлөрсөн засаг захиргаатай, цэрэг-улс төрийн хүчирхэг байгуулалтай байжээ. Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны аравдугаар сарын 15-ны өдрийн 216 дугаар зарлигаар Монголын тулгар төрийн 2220 жилийн ойг тэмдэглэхээр шийдвэрлэсэн. Энэ үеэс эхлэн Үндэсний их баяр наадмыг тэмдэглэхэд Тулгар төр байгуулагдсан ойг мөн дурдаж заншсан боловч энэ талаар хуульд тусгайлан заагаагүй байдаг.

Монгол Улсын түүхэнд 200 гаруй жил үргэлжилсэн Манж Чин гүрний ноёрхлыг эцэс болгон монгол төрийг сэргээн байгуулж, монголчуудын сэргэн мандлын эхийг тавьсан 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал нь төрт ёсны өнө эртний уламжлалтай Монголын ард түмний түүхийн онцгой хуудас, хойч үе нь бахархан дурсвал зохих түүхт үйл явдал мөн билээ. 1911 оны арванхоёрдугаар сарын 29-нд Монгол Улс тусгаар тогтнолоо зарлаж, Богд хааныг Монгол Улсын хаан ширээнд өргөмжилж, Богд хаант Монгол Улс байгуулагдсан. Үүний үр дүнд Монгол Улс Манж Чин улсын дарлалаас гарч, тусгаар тогтносон буюу шинэ засаглал тогтож, төрийн шинэ бүтэц бий болжээ.

1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд Монгол Улсад олон намын улс төрийн тогтолцоо үүсэн хөгжиж, өнөөгийн ардчилсан Үндсэн хууль батлагдсан билээ. Монголын ардчилсан хувьсгал нь нэг намын, төвлөрсөн засаглалын тогтолцооноос олон намын, ардчилсан улс төрийн тогтолцоонд тайван замаар шилжих үндэстнийг хамарсан нийгмийн хөдөлгөөн байсан юм. Энэ хувьсгал нь дэлхийн ардчилсан хөдөлгөөн, нийгмийн шинэчлэлийн санаа сэдлээс урам зориг авч, иргэдийн эрх, эрх чөлөө, ил тод засаглалыг бататгахыг зорьсон тайван, хүчирхийллээс ангид эрс өөрчлөлтийн үйл ажиллагаа байсныг олон нийт зүй ёсоор хүлээн зөвшөөрдөг.

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, эх орондоо иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон байдаг. Тулгар төр байгуулагдсаны ой, Их Монгол Улс байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгал, Ардын хувьсгал, Ардчилсан хувьсгал нь Монголчууд бидний төрт ёс, түүхийн салшгүй нэг хэсэг билээ. Тиймээс Үндэсний их баяр наадмаа тэмдэглэхдээ эдгээр үйл явдлыг санан дурсаж, үндэсний ухамсраа сэрээж байх нь зүй ёсны хэрэг юм.

Их Монгол Улс байгуулагдсаны ой, Ардын хувьсгалын ойн баяр наадамтай хамт Тулгар төр байгуулагдсаны ой, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, Ардчилсан хувьсгалын ойг Үндэсний их баяр наадмын тухай хуульд албан ёсоор заах нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт баяр болох Үндэсний их баяр наадмыг агуулгыг бүрэн илэрхийлэх болно гэж үзэж байна.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн хоёрдугаар зүйлээр уг хуулийг 2025 оны 7 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх зохицуулалтыг тусгасан.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хоёр зүйлтэй. Нэгдүгээр зүйлд, тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.10 дахь хэсгийг шинэчилж найруулахаар тусгасан. Энэ төслийн хүрээнд санал болгож буй зохицуулалтыг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжтой харьцуулбал дараах байдалтай байна. Үүнд:

<i>Хуулийн зохицуулалт</i>	<i>Төсөлд тусгасан байдал</i>
5.10.Их Монгол Улс байгуулагдсаны ой болон үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Ардын хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ.	5.10.Тулгар төр байгуулагдсаны ой, Их Монгол Улс байгуулагдсаны ой, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Үндэсний эрх чөлөөний хувьсгал, Ардын хувьсгал, Ардчилсан хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ.

Их Монгол Улс байгуулагдсаны ой, Ардын хувьсгалын ойгоос гадна Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, Ардчилсан хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх талаар хуульд өөрчлөлт оруулж байгаа бөгөөд утга найруулгын хувьд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.10 дахь хэсгийг өөрчлөн найруулав.

Тулгар төр байгуулагдсан үйл явдал, Үндэсний эрх чөлөөний хувьсгал, Ардчилсан хувьсгал нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүхтэй салшгүй холбоотой.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны аравдугаар сарын 15-ны өдрийн 216 дугаар зарлигаар Монголын тулгар төрийн 2220 жилийн ойг тэмдэглэхээр шийдвэрлэсэн. Улмаар Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Ой тэмдэглэх тухай /Хүннү гүрний 2220 жил/ 314 дүгээр тогтоолоор Хүннү гүрэн байгуулагдсаны 2220 жилийн ойг 2011 оны туршид тэмдэглэхээр тогтоосон. Энэ үеэс эхлэн Үндэсний их баяр наадмыг тэмдэглэхэд Тулгар төр байгуулагдсан ойг дурдаж заншсан боловч энэ талаар хуульд тусгайлан заагаагүй байдаг.

Монголын тулгар төр гэж Монголын нутаг дэвсгэр дээр байгуулагдсан анхны төрт улсыг хэлэх бөгөөд үүнийг Хүннүгийн эзэнт гүрэн (МЭӨ III зуун – МЭ 93 он)-тэй холбон ойлгодог. Хүннү улс нь Монголын газар нутаг дээр үүссэн анхны төрт улс бөгөөд төвлөрсөн засаг захиргаатай, цэрэг-улс төрийн хүчирхэг байгуулалтай

байжээ. Тулгар төр гэдэг нь тухайн ард түмэн анх удаа улс байгуулж, төрт ёсны уламжлал тавигдсан гэсэн утгатай. Монголчуудын хувьд Хүннү гүрэн анхны төрт улс болж, түүний залгамж халааг Сяньби, Жужан, Түрэг, Уйгур зэрэг улс гүрнүүд үргэлжлүүлэн хөгжүүлсэн гэж үздэг. Хожим нь XIII зуунд Чингис хаан Их Монгол улсыг байгуулснаар Монголын төрийн уламжлал дахин сэргэсэн юм. Харин "тулгар төр" гэдэг ойлголтыг ихэвчлэн Хүннүгийн үед хамааруулдаг. Тиймээс Тулгар төрийн тухай ойлголт нь Монголын ард түмэн, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалтай салшгүй холбоотой.

Монгол Улсын түүхэнд 200 гаруй жил үргэлжилсэн Манж Чин гүрний ноёрхлыг эцэс болгон монгол төрийг сэргээн байгуулж, монголчуудын сэргэн мандлын эхийг тавьсан 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал нь төрт ёсны өнө эртний уламжлалтай Монголын ард түмний түүхийн онцгой хуудас, хойч үе нь бахархан дурсвал зохих түүхт үйл явдал мөн билээ. Манж Чин улсын эрхшээлээс гарч, тусгаар тогтнолоо сэргээх үндэсний тэмцэл болох 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал монголчуудын түүхэнд онцгой ач холбогдолтой. 1911 оны арванхоёрдугаар сарын 29-нд Монгол Улс тусгаар тогтнолоо зарлаж, Богд хааныг Монгол Улсын хаан ширээнд өргөмжилж, Богд хаант Монгол Улс байгуулагдсан. Үүний үр дүнд Монгол Улс Манж Чин улсын дарлалаас гарч, тусгаар тогтносон буюу шинэ засаглал тогтож, төрийн шинэ бүтэц бий болжээ.

2011 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ойн баярыг тохиолдуулж Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр гэх тодотголтойгоор 12 дугаар сарын 29-ний өдрийг нэмсэн байдаг.

1989-1990 онд Монгол Улсад өрнөсөн ардчилсан хувьсгал нь олон нийтийг хамарсан жагсаал цуглаан, өлсгөлөн зэрэг улс төрийн тэмцлийн олон хэлбэрийг агуулсан үргэлжилсэн үйл явц байсан бөгөөд эдгээрийн үр дүнд коммунист дэглэм бүхий Бүгд Найрамдах Монгол Ард Улсын удирдлага бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч, Монгол Улс эргэлт буцалтгүй ардчиллын замыг сонгосон юм.

Монголын ардчилсан хувьсгал нь нэг намын, төвлөрсөн засаглалын тогтолцооноос олон намын, ардчилсан улс төрийн тогтолцоонд тайван замаар шилжих үндэстнийг хамарсан нийгмийн хөдөлгөөн байв. Энэхүү хувьсгал нь дэлхийн ардчилсан хөдөлгөөн, нийгмийн шинэчлэлийн санаа сэдлээс урам зориг авч, иргэдийн эрх, эрх чөлөө, ил тод засаглалыг бататгахыг зорьсон тайван, хүчирхийллээс ангид эрс өөрчлөлтийн үйл ажиллагаа байсныг олон нийт зүй ёсоор хүлээн зөвшөөрдөг.

1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд Монгол Улсад олон намын улс төрийн тогтолцоо бий болж, өнөөгийн ардчилсан Үндсэн хууль батлагдсан билээ. Монголын ард түмэн Үндсэн хуулийн зорилгыг тодорхойлохдоо, *"Монголын ард түмэн бид улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,*

хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно" гэсэн байдаг. Монгол Улсын нэн шинэ түүхийн хамгийн чухал үйл явдлын нэг болох Ардчилсан хувьсгал нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалтай салшгүй холбоотой билээ.

Их Монгол Улс байгуулагдсаны ой, Ардын хувьсгалын ойн баярын хамт Тулгар төр байгуулагдсаны ой, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ойн, Ардчилсан хувьсгалын баярын ойд улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэхээр Үндэсний их баяр наадмын тухай хуульд албан ёсоор тусгах нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт баяр болох Үндэсний их баяр наадмыг агуулгыг бүрэн илэрхийлэх болно гэж үзэж байна.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн хоёрдугаар зүйлээр уг хуулийг 2025 оны 7 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх зохицуулалтыг тусгасан.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Уг судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ын дагуу гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол үндэстний дэлхийн олон улсаас ондооших гол ялгарал, түүх соёлын илэрхийлэл бол Үндэсний их баяр наадам билээ. Өнө мөнхөд мандан бадрахуйн тайлал болсон нар, сар, галыг бэлгэдэн, эв нэгдэл, төрт ёс, бахархлыг зөгнөдөг монгол наадам нь эрхэмсэг оршихуй, ижилсэн эвлэхүй, бахдан омогшихуйн утга учиртай. Зуны дэлгэр цагт зон олноороо тэмдэглэн өнгөрүүлдэг энэхүү баярын талаар түүхийн хуудаснаас сөхөн үзвэл эртний түүхийн хувьд Хүннүгийн үед очих аж.

Жил бүрийн 7 дугаар сарын 11, 12, 13-ны өдрүүдэд улс даяар өргөн дэлгэр тэмдэглэгддэг Үндэсний их баяр наадам нь Хүннү гүрний нэгдсэн төр байгуулагдсан үе буюу МЭӨ I-II зууны үеэс эхтэй гэж үзэж болно. Тухайн үеийн сурвалж, бичгүүдэд наадмын талаар дурдсан байдаг нь үүнийг гэрчлэх төдийгүй морь, бөх, сурыг тулгар төрийн үүсэл хэмээн үздэг байв. Хүннүчүүд бутархай овог аймгийн эв нэгдэл, цэргүүдийн байлдааны ур чадварыг сайжруулах зорилгоор наадам зохион байгуулж ирсэн нь өдгөө монгол угсаатнуудын эрийн гурван наадмын төрхийг олсон байдаг. Түүнчлэн Монголын нууц товчоонд эрийн гурван наадмыг "Хуран сар" буюу 07 дугаар сард тэмдэглэдэг байсан тухай дурдсан нь бий.

1639 онд Өндөр Гэгээн Занабазарыг халхын шашны тэргүүнээр өргөмжилж "Даншиг наадам"-ыг анх зохион байгуулсан түүхтэй. Ширээт цагаан нуурын уг наадамд Бөх лам барилдан түрүүлж, Бонхор донир гэгчийн морь магнайлсан нь тэмдэглэгдэн үлджээ. Үүний дараа 1772 онд Хэнтий уулыг тахих их наадам болж тус наадмыг "Арван засгийн наадам" хэмээн нэрийдэн 1912 оноос жил бүр хийх төрийн наадам болгов. Энэхүү наадам Богд хааныг таалал төгсөх хүртэл буюу 1925 он хүртэл үргэлжилсэн юм.¹

"Арван засгийн наадам"-тай зэрэгцэн 1922 оноос эхлэн "Ардын төрийн наадам"-ыг тэмдэглэж эхлэв. Бүгд Найрамдах Монгол Ард Улс бүрэлдэн тогтсоны дараа хоёр наадмыг хамтатгах шийдвэр гаргасан бөгөөд 1925 оны 5 сарын 15-ны Засгийн газрын хуралдаанаар наадмын товыг 7 дугаар сарын 11-нд байхаар шийдвэрлэсэн нь өнөөг хүртэл хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа билээ. Харин 1946 оноос "Ардын хувьсгал ялсны ой" хэмээн тодотгох болсон байдаг. 2003 онд "Үндэсний их баяр наадам"-ын тухай хуулийг баталсан ба уг хуулийн 2.1-т "Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт их баяр мөн" гэсэн байдаг бол 2022 онд

¹ <https://enaadam.mn/about/history>

шинэчилсэн найруулга хэлбэрээр батлагдсан Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 4.1.1-т, Үндэсний их баяр наадам бол "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт баяр" гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, 2022 онд батлагдсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд Үндэсний их баяр наадмын зорилго, цар хүрээг илүү өргөн хэмжээнд авч үзжээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээ

2003 оны Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2.5-д "Их Монгол Улс байгуулагдсаны тэгш ой, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Ардын хувьсгалын ой болон нийслэлийн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ" гэж заасан. Харин 2022 оны Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5.10-т "Их Монгол Улс байгуулагдсаны ой болон үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Ардын хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ" гэж заажээ. Тодруулбал, 2003 оны хуульд Их Монгол Улс байгуулагдсаны зөвхөн тэгш ойг тэмдэглэхээр заасан байсан бол 2022 оны хуулиар зөвхөн тэгш гэлтгүй бүх ойг тэмдэглэхээр зохицуулсан байна.

Уг хуульд Үндэсний их баяр наадмаар Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ойг тэмдэглэх талаар тусгайлан заагаагүй боловч Монгол Улс жил бүр эдгээр ойг Үндэсний их баяр наадамд хамааруулан тэмдэглэж байна. Түүнчлэн ардчилсан хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэхээр заагаагүй ч зарим жил тэмдэглэж байна. Тухайлбал, 2020 онд Ардчилсан хувьсгалын 30 жилийн ойг Үндэсний их баяр наадамтай хамтатган тэмдэглэсэн.

Тиймээс Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 4.1.1-т заасанчлан Үндэсний их баяр наадам нь "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүхийг илэрхийлсэн соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт баяр"-ын хувьд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүхэнд ач холбогдлоороо онцгой үүрэг гүйцэтгэсэн үйл явдлууд буюу Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгал, Ардчилсан хувьсгалын ойг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх асуудлыг хуульчлан тогтоох зайлшгүй шаардлага байна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох

Үндэсний их баяр наадам гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт баярыг хэлдэг учраас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх тухайлсан нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж,

байгууллага, бусад этгээдийг тодорхойлох боломжгүй бөгөөд уг хуулийн үйлчлэл нийт Монгол Улсын ард түмнийг хамарна.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасны дагуу хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болдог. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 1.1.-т зааснаар уг хуулийн зорилт нь Үндэсний их баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх, Үндэсний их баяр наадмын хүрээнд үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, үндэсний хурдан морины уралдаан, шагайн харвааг зохион байгуулах, цол, чимэг олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршдог. Өөрөөр хэлбэл, хууль дээдлэх үндсэн зарчмын хүрээнд Монгол Улсад Үндэсний их баяр наадмыг зохион байгуулахад Үндэсний их баяр наадмын тухай хуулийг баримтлах ба дагаж мөрдөнө.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгал, Ардчилсан хувьсгалын ойг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх талаар хуульчлан тогтоогоогүй байхад эдгээр тэмдэглэлт онцгой үйл явдлыг улсын баяр наадамтай тэмдэглэх талаар үйл ажиллагаа явагдах нь хууль эрх зүйн зохицуулалтгүй буюу сайн дурын шинжтэй болж хувирч байгаа болно.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн эрхэм зорилго нь улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх, төрт ёс, түүхийг нандигнан өвлөх, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэх, эх орондоо иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхэд оршдог.

Тэртээ 2200 гаран жилийн өмнө Монголчуудын өвөг дээдсийн байгуулсан Хүннү гүрэн нь Ази - Европын хээр талын нүүдэлчдийг эмхлэн нэгтгэсэн анхны эзэнт гүрэн байсны хувьд Тулгар төр байгуулагдсаны ойн байр нь Монгол улс төдийгүй бусад нүүдэлчин ард түмний төрт ёсны баярт зүй ёсоор тооцогдоно. Монголын тулгар төр Хүннү гүрэн байгуулагдсаны ойг тэмдэглэх үйл ажиллагааг хуульчлан тогтоох нь Монголын төр, нүүдэлчдийн ертөнцөд анхных болоод зогсохгүй соёл иргэншилт хөрш улс гүрнүүдтэй эн тэнцүү харьцаж байсан бодит түүх, төрт ёсны өнө эртний уламжлал агуулгыг албан ёсоор тэмдэглэх боломжийг бүрдүүлэх юм.

Монгол Улсын түүхэнд 200 гаруй жил үргэлжилсэн Манж Чин гүрний ноёрхлыг эцэс болгон монгол төрийг сэргээн байгуулж, монголчуудын сэргэн мандлын эхийг тавьсан 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал нь төрт ёсны өнө эртний уламжлалтай Монголын ард түмний түүхийн онцгой хуудас, хойч үе нь бахархан

дурсвал зохих түүхт үйл явдал мөн. Энэхүү Үндэсний эрх чөлөөний хувьсгал нь монголчуудын туурга тусгаар улсаа сэргээн байгуулах гэсэн олон арван жилийн мохошгүй хүсэл тэмүүлэл, тууштай тэмцлийн биелэл, үндэсний ухамсрын их сэргэлтийн эхлэл байсан гэж Монголын ард түмэн, түүхч судлаачид хүлээн зөвшөөрдөг. Тиймээс бодит түүх, төрт ёсны уламжлал агуулгаараа Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ойг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэхийг хуульчлан тогтоох шаардлагатай.

1980-аад оны сүүл үед ЗХУ болон бусад социалист орнуудад ардчилал, шинэчлэлийн хөдөлгөөн эхэлсэн бөгөөд ардчилсан хувьсгал тэмцэл өрнөж амжилтад хүрсний нэг Монгол Улс билээ. 1989-1990 оны хооронд үргэлжилсэн ардчилсан хувьсгалын улс төрийн тэмцэл, жагсаал цуглаан, өлсгөлөнгийн үр дүнд коммунист дэглэмтэй Бүгд Найрамдах Монгол Ард Улсын удирдлага бүрэн огцорч, ардчилсан Монгол Улс байгуулагдсан. Өөрөөр хэлбэл, 1990 оны ардчилсан хувьсгал бол Монгол орны улс төр, эдийн засгийн тогтолцоо, хөгжлийн чиг хандлагыг эрс өөрчилж, ардчилсан хөгжлийн замд оруулсан түүхэн үйл явц юм. Энэхүү хувьсгалт үйл явдлын үр дүнд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн Арван хоёрдугаар зүйлийн 4-т заасан *"Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл"* болж, түүнийг Үндэсний их баяр наадмын төв талбайн хойморт залан Үндэсний их баяр наадмыг нээдэг билээ. Тиймээс бодит түүх, төрт ёсны уламжлал агуулгаараа Ардчилсан хувьсгалын ойг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх талаар хуульчлан тогтоох шаардлагатай.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Үндэсний их баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдсон харилцааг Үндэсний их баяр наадмын тухай хуулиар зохицуулдаг.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5.10-т, *"Их Монгол Улс байгуулагдсаны ой болон үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Ардын хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ"* гэж заасан ба тухайн харилцааг шууд хуулиар тогтоон зохицуулсан. Тиймээс тухайн харилцаатай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй хууль тогтоомжийн төсөл боловсруулах хууль зүйн шаардлагатай учир хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгов. Хууль тогтоомжийн төсөл нь бүтэц, агуулгын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24.5.1-т заасанчлан хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн төрөл байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДЛАХ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэв.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хүний эрхэд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Эдийн засагт ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ. Үндэсний их баяр наадмын тухай хуульд улсын баяр наадмыг Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгал, Ардчилсан хувьсгалын ойтой хамтатган тэмдэглэх талаар албан ёсоор хууль тогтоох түвшинд хүлээн зөвшөөрч хууль гаргаснаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх, төрт ёс, түүх уламжлалыг нандигнан өвлөх Үндсэн хуулийн зорилгыг биелүүлж, нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Хүснэгт 1

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
